

**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ**

2015.12

Үзүүлэлтүүд:



<p>ДНБ 2.5% 2015 оны III-р улирал</p>	<p>ГШХО 11-р сард 6.9 сая ам.доллар</p>	<p>Төсвийн тэнцэл -1163.2 тэр бум төгрөг</p>	<p>Инфляци 1.9%</p>	<p>Чанаргүй зээл 825 тэрбум төгрөг</p>	<p>Валютын нөөц 1.4 тэрбум ам.доллар</p>
<p>ХАА салбар 12.8%, аж үйлдвэр, үйлчилгээний салбар 6.2%-иар тус тус өссөн нь нөлөөлөв.</p>	<p>Цэвэр ГШХО 11-р сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 142.8 сая ам доллараар өсч, өмнөх сараас 47.6 сая ам.доллараар буурч 6.9 сая ам доллар болов.</p>	<p>Төсвийн орлого 5.97 их наяд төгрөг, зарлага 7.13 их наяд төгрөг, тэнцэл (1163.2) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.</p>	<p>Өмнөх сараас 0.2 хувь буурч, оны эхнээс 1.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1.9 хувиар өслөө.</p>	<p>Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 2.9% буюу 25 тэрбум төгрөгөөр буурч, 825 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд ээлэх чанаргүй зээл 7%</p>	<p>Монголбанкны валютын нөөц өмнөх сараас 3.7% буюу 52 сая ам.доллараар өсч 1459 сая ам.доллар болов.</p>
<p>\$</p> <p>Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 1995.51</p>	<p>House</p> <p>Орон сууцны үнийн индекс 1.055 Өмнөх сараас 1.1%-иар, оны эхнээс 11.3%-иар тус тус буурлаа.</p>	<p>Bank</p> <p>Монголбанкны бодлогын хүү 13%</p>			



Монгол төрийн тусгаар тогтнол, дахин сэргэн мандсны түүхт 104 жилийн ой энэ сарын 29-ний өдөр болж бүх нийтээр амрав. Эл өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн цомын төлөөх чансаа өндөр шилдэг 128 бөхийн барилдаан энэ жил тав дахь удаагаа Бөхийн өргөөнд боллоо.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, оны эцсийн байдлаар хүснэгтээр үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2012 он		2013 он		2014 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	20574	1 880 396	18 194	1 116 153	1 106	850 615
Төмрийн хүдэр	6415	532 509	6725	654 333	8 338	448 378
Зэсийн баяжмал	575	838 780	650	948 951	1 378	2 575 636
Нийт	27564	3 251 685	25 569	2 719 437	10 822	3 874 629

Эх сурвалж: УСХорло

12-р сарын 1-нээс эхлэн гэр хорооллын хэрэглэгчдийн нэг киловатт цаг эрчим хүчний шөнийн тарифыг 50 хувь хөнгөлж, 38.55 төгрөгт шилжүүлэв.


Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

ДНБ ДНБ 2015 оны 3-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 11 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 286.4 тэрбум төгрөг буюу эдийн засгийн өсөлт 2.5% болов. Үүнд ХАА салбар 12.8%, аж үйлдвэр, үйлчилгээний салбар 6.2%-иар тус тус өссөн нь нөлөөлөв. Эдийн засгийн өсөлт ийнхүү удаашралтай байгаа нь аж үйлдвэр, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт бага байгаатай холбоотой.



Төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ арванхоёрдугаар сард 5.97 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 7.13 их наяд төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1163.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 295.2 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 4.7 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.



Валютын ханш

Арванхоёрдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 112.51 төгрөг буюу 6 хувь, өмнөх сараас 0.1 төгрөгөөр суларч 1995.51 төгрөгт хүрэв. Өмнөх сараас 2.61 төгрөгөөр нэмэгдэв.



Инфляци


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2015 оны 12-р сард өмнөх сарынхаас 0.2% буурсан хэдий ч өмнөх оны мөн үеийнхээс 1.9% өссөн байна. Индекс өмнөх сарынхаас 0.2 хувиар буурахад орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 1.8 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, Монголбанк

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2015 оны 11 сарын байдлаар 1459 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 3.7% буюу 52 сая ам.доллар, өнгөрсөн оны мөн үеэс 7.9 хувь буюу 107 сая ам.доллараар тус тус өссөн бол оны эхнээс 11.5% буюу 191 сая ам.доллараар буурсан байна.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс


2015 онд 898.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 41.7 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх оныхоос гүйлгээ 702.3 тэрбум төгрөг буюу 4.6 дахин өсч, арилжигдсан үнэт цаас 10.6 сая ш буюу 20.2 хувиар буурсан байна. 2015 оны 12 дугаар сард 58.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 12 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх сарынхаас гүйлгээ 15.8 тэрбум төг буюу 36.9 хувиар өсч, арилжигдсан үнэт цаас 10.4 сая ш буюу 7.6 дахин өссөн байна. ТОП-20 дундаж индекс тайлант сард 12279 болж, өмнөх сарынхаас 459.7 нэгж, өмнөх оныхоос 2554 нэгжээр буурчээ.



*Монголын хөрөнгийн бирж


Мөнгө

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны арванхоёрдугаар сарын эцэст 10 их наяд төгрөг болж, өмнөх сараас 8.80 тэрбум төгрөг буюу 89.8%-иар, өмнөх оны мөн үеэс 9.63 тэрбум төгрөг буюу 90.5%-иар тус тус буурчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тайлант сард 706.6 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 4 тэрбум төгрөг буюу 0.5%, өнгөрсөн оны мөн үеэс 103 тэрбум төгрөг буюу 12.7%-иар буурчээ.



Хадгаламж

Нийт хадгаламж 2015 оны 12-р сард 7.3 их наяд төгрөг болж өмнөх сараас 148 тэрбум төгрөг буюу 4.6 хувиар өссөн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 2.99 тэрбум буюу 0.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү өмнөх сараас нийт хадгаламж өсөхөд төгрөгийн хадгаламж 4.6 хувиар буюу 238.3 тэрбум төгрөг, валютын хадгаламж 4.4 хувиар буюу 89.5 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.




Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны арван хоёрдугаар сарын байдлаар 11.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 194 тэрбум төгрөг буюу 1.6%-иар, өмнөх оны мөн үеэс 807 тэрбум төгрөг буюу 6.5%-иар тус тус буурлаа. Харин чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 825 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 2.9% (25 тэрбум төгрөг)-өөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 31.8% (199 тэрбум төгрөг)-өөр өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл хэмжээ 7%-ийг эзэлж байна.



Ипотекийн зээл


2015 оны 12-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.6 хувь (20.0 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 20.7 хувь (588.3 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 3.4 их наяд төгрөгт хүрэв. Арванхоёрдугаар сард нийт 522 зээлдэгчид 20 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 77105-д хүрлээ. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.7 хувь нь төгрөгийн, 1.3 хувь нь гадаад валютын зээл байгаа ба нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээл 0.7 хувийг эзэлж байна.



* Эх сурвалж Монголбанк

Гадаад худалдаа

Гадаад худалдаа 2015 оны арванхоёрдугаар сард худалдааны нийт бараа эргэлт 8.5 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 4669.5 сая ам.доллар, импорт 3797.2 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 872.3 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 2544 сая ам.доллар буюу 23.1 хувь, үүний дотор экспортын хэмжээ 1105 сая ам.доллар буюу 19.1 хувиар, импортын хэмжээ 1439 сая ам.доллар буюу 27.4 хувиар тус тус буурчээ. Үүнд, эрдэс бүтээгдэхүүний экспорт 1113.1 сая ам.доллар, нэхмэл бүтээгдэхүүнийх 36.1 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



* Эх сурвалж ҮСХ, МонголБанк

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2015 оны арваннэгдүгээр сард 6.9 сая ам.долларын эерэг дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 142.8 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад 47.6 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна. МУ-аас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -1.1 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 62.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.




* Эх сурвалж МонголБанк


Монгол Улсын гадаад өр

Гадаад өр

2015 оны гуравдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 3.5 тэрбум ам.доллар, нийт гадаад өрийн үлдэгдэл 21.4 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 5.3 хувь (199.9 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 0.8 хувь (190 сая ам.доллар)-аар тус тус буурсан байна. Тайлант улиралд улсын нийт гадаад өрийн 16 хувийг засгийн газрын өр, 10 хувийг Төв банкны өр 9 хувийг, 16 хувийг бусад салбаруудын өр, 49 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 97 хувийг богино хугацаат, 3 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ ХУВИАР



* Эх сурвалж Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төсөөлөл

Үзүүлэлтүүд	2014.09.3 Гүйцэтгэл	Тэрбум төгрөг		
		2015 он	2016 он	2017 он
ЗГ-ын гадаад зээлийн өр	3,911.50	4,089.20	4,299.10	4,169.30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2,760.80	2,625.00	2,550.00	2,490.00
Засгийн газрын баталгаа	2,305.50	2,515.80	2,439.20	1,312.50
Засгийн газрын гадаад өрийн дүн	8,977.80	9,230.00	9,288.30	7,971.80

* Эх сурвалж Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

Гадаад өр, зээлжих зэрэглэл

Зээлжих зэрэглэл	S&P		Fitch		
	Монгол Улс	В	Тогтвортой	В	Сөрөг
Огноо	2015.11.05		2013.12.13		

Standard & Poor's Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 11-р сард "B+" зэрэглэлээс "B" зэрэглэлд болгож бууруулав. Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан шалтгааныг тэд гадаадын хөрөнгө оруулалт буурсан, гадаад валютын урсгал багассан, өрийн ачаалал үүсч болох эрсдэлт нөхцөл үүссэнтэй холбон тайлбарлаж байна.

Moody's :

Moody's агентлаг нь зээлжих зэрэглэлийг тогтоохдоо C ангиллаас AAA хүртэл 21 ангилалд зэрэглэл тогтоодог ба мөн хэтийн төлөвийг сөрөг, тогтвортой гэж үнэлдэг.

Огноо	Зээлжих зэрэглэл	Хэтийн төлөв
2005 оны 10 дугаар сар 4-нд	B1	Тогтвортой
2009 оны 6 дугаар сарын 10-нд	B1	Сөрөг
2009 оны 10 дугаар сарын 30-нд	B1	Тогтвортой
2014 оны 5 дугаар сарын 26-нд	B1	Сөрөг
2014 оны 7 дугаар сарын 17-нд	B2	Сөрөг

Moody's 2014 оны 7-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан.

Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B1 -ээс B2 сөрөг болгож бууруулсан. Үүний шалтгааныг Монгол Улсын гадаад өрийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өссөн, инфляци өндөр байгаа нь чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж, банкны системийг бүхэлд нь эрсдэлд оруулах магадлалтай гэж үзжээ. Түүнчлэн гадаад валютын нөөц буурч байгааг эрсдэлд тооцжээ.

Үүний зэрэгцээ Moody's засгийн газрын үнэт цаас гаргагч ба бондын үнэлгээг B1, засгийн газрын дунд хугацаат өрийн бичгийн үнэлгээг B1, мөн богино хугацааны үнэлгээг "not prime" буюу төлбөрийн чадвар сул зэрэглэлд хэвээр үлдээсэн.

- 12.14 Нийслэлийн иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх цахим бүртгэлийн V ээлж эхлэв.
- 12.15 МУ-ын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн урилгаар БНСУ-ын 44 дэх Ерөнхий сайд Хван Гё Ан Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, БНСУ-ын Ерөнхий сайд Хван Гё Ан нар албан ёсны хэлэлцээ хийж, Харилцаа хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурлаа. Энэхүү айлчлал Монгол Улс, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ойн хүрээнд өрнөж байгаагаараа онцлог юм.
- 12.15 Оюутолгой төслийн гүний уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх 4.4 тэрбум ам.долларын санхүүжилтийн гэрээг баталгаажууллаа.

Тойм

2015 оны тойм

2015 оны нэгдүгээр улиралд 4 хувь, эхний 6 сарын байдлаар 3.3 хувьтай байсан ДНБ 2015 оны 3-р улирлын байдлаар 2.5 хувьд хүрч буурав. ДНБ-ий өсөлтийг хөдөө аж ахуйн салбар голлон бүрдүүлжээ. Учир нь уул уурхай, барилга, худалдааны салбарын эргэлт эрс багассантай холбоотой. Инфляцийн түвшин сүүлийн саруудад тогтмол буурч 12-р сарын байдлаар 1.9 хувь болж мах, хүнсний ногоо, бэлэн хувцасны үнэ буурахад голлон нөлөөлжээ. 2015 оны гуравдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 3.5 тэрбум ам.доллар, нийт гадаад өрийн үлдэгдэл 21.4 тэрбум ам.доллар болов. Гадаадын шууд хөрөнгө оруулалт 1 болон 3 улиралд алдагдалтай байсан бол 2, 4-р улиралд ашигтай гарав. Хүндрэлтэй байсан эдийн засгийн салбар 2015 оны эцэст буюу 12-р сард Оюутолгой төслийн гүний уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх 4.4 тэрбум ам.долларын санхүүжилтийн дэлхийн 15 банк, санхүүгийн байгууллагууд авахаар болов. Тус гэрээг баталгаажуулснаар манай улсын зээлжих зэрэглэл, гадаадын хөрөнгө оруулалт, ханшийн тогтворжилтод эерэгээр нөлөөлнө гэсэн хүлээлт байна. Энэхүү гэрээ хэрэгжсэнээр Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт 5-7 жилийн хугацаанд үргэлжлэх бөгөөд Монгол Улсад жил бүр нэг тэрбум гаруй ам.долларын урсгал орж ирэх үүд хаалга нээгдэж байна.